

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Баруун-Урт	Утас: 99029193 Цахим хаяг: naranuyam@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
	Аудитор: Утас: 91009002 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Зөвлөмж	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 84

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА, ХОШУУЧ Э.ЭНХСАЙХАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн аудитын хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй, тухайн жилд худалдан авах арван сая төгрөгөөс дээш өртөг бүхий барааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй зэрэг нь УСНБООУС, Төрийн хэмнэлтийн тухай хууль, "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам", Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартад нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 99.8 хувийн биелэлтэй хэрэгжүүлсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,678,340.40	44,629,697.71
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,000.00	746,400.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	40,000.00	746,400.00
3121	Төгрөг	40,000.00	746,400.00
31211	Төрийн сангийн харилцах	40,000.00	746,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,638,340.40	43,883,297.71
351	Түүхий эд материал	17,836,412.50	18,179,293.41
35110	Тусгай зориулалттай материал	16,811,320.40	16,925,320.41
35130	Эм боох материал	1,025,092.10	1,253,973.00
354	Хангамжийн материал	21,801,927.90	25,704,004.30
35410	Бичиг хэргийн материал	334,480.00	2,208,060.00
35420	Аж ахуйн материал	17,899,319.50	20,175,849.50
35440	Түлш, шатах тослох материал	650.00	-
35450	Барилгын засварын материал	1,079,100.00	1,097,850.00
35460	Хүнсний материал	2,488,378.40	2,222,244.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	601,978,451.10	654,507,011.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	601,978,451.10	654,507,011.83
392	Биет хөрөнгө	550,272,451.10	600,142,678.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	539,297,870.00	539,297,870.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,280,999.49)	(56,551,221.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,150,000.00	49,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(155,649,999.88)	(26,888,888.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,107,996.31	126,091,146.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,658,150.86)	(48,641,173.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,905,620.00	21,746,072.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,980,586.58)	(10,470,867.75)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,450,000.00	4,450,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,983,654.00	6,152,864.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,052,952.40)	(4,043,122.91)
393	Биет бус хөрөнгө	51,706,000.00	54,364,333.33
39301	Програм хангамж	6,417,692.31	2,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,417,692.31)	(241,666.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,706,000.00	51,706,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	641,656,791.50	699,136,709.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	40,000.00	746,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,000.00	746,400.00
413	Өглөг	40,000.00	746,400.00
4136	Бусад өглөг	40,000.00	746,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	40,000.00	746,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	641,616,791.50	698,390,309.54
51	Засгийн газрын хувь оролцоо	641,616,791.50	698,390,309.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	138,665,624.90	138,665,624.90
51101	Өмч: - төрийн	138,665,624.90	138,665,624.90
512	Хуримтлагдсан үр дүн	176,610,146.13	233,383,664.17
51210	Өмнөх үеийн үр дүн	194,478,368.32	176,610,146.13
51220	Тайлант үеийн үр дүн	(17,868,222.19)	56,773,518.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	326,341,020.47	326,341,020.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	641,656,791.50	699,136,709.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	549,083,288.00	645,416,947.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,656,948.00	75,637,547.01
120	Нийтлэг татварын бус орлого	27,656,948.00	75,637,547.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,656,948.00	75,637,547.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,528,250.00	2,685,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,128,698.00	72,952,547.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521,426,340.00	569,779,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,621,700.00	559,779,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,621,700.00	559,779,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,804,640.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,990,000.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,814,640.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	566,951,510.19	588,643,428.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	566,951,510.19	588,643,428.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,054,736.32	584,211,550.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,660,786.73	413,559,585.66
210101	Үндсэн цалин	243,453,800.00	264,432,694.33
210102	Нэмэгдэл	141,987,300.00	125,520,802.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	972,000.00	11,380,085.87
210104	Урамшуулал	1,247,686.73	12,226,003.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,811,243.72	8,317,804.15
210201	Тэтгэврийн даатгал	-	120,450.43
210202	Тэтгэмжийн даатгал	-	14,170.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	11,336.51
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,834.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,811,243.72	8,169,012.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,873,053.97	50,426,439.14
210301	Гэрэл, цахилгаан	8,237,737.78	6,664,539.14
210302	Түлш, халаалт	39,665,696.19	39,501,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,969,620.00	4,260,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,028,066.47	18,872,857.12
210401	Бичиг хэрэг	2,219,604.00	2,363,120.00
210402	Тээвэр, шатахуун	11,116,290.00	11,228,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,542,695.77	2,825,067.12
210404	Ном, хэвлэл	2,450,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	132,700.00	108,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,287,816.10	1,665,520.00
210408	Бараа материал акталсны зардал	7,278,960.60	682,000.00
2105	Нормативд зардал	25,686,322.60	32,384,380.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	899,158.90	1,001,967.10
210502	Хоол, хүнс	24,787,163.70	31,382,413.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,072,900.00	9,830,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,300.00	208,800.00
210604	Урсгал засвар	15,755,600.00	9,621,850.00
2107	Томилот, зочны зардал	106,000.00	553,400.00
210702	Дотоод албан томилот	106,000.00	553,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,018,678.74	6,616,987.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,371,778.74	5,558,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	599,400.00	379,487.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	938,500.00	554,500.00

210807	Газрын төлбөр	43,000.00	36,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,797,684.09	43,649,446.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	243,166.00	377,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	241,600.00	197,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,312,918.09	43,074,346.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,896,773.87	4,431,878.93
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	285,600.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	285,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,362,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,362,000.00	420,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	249,173.87	4,011,878.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	249,173.87	4,011,878.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,868,222.19)	56,773,518.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,868,222.19)	56,773,518.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	526,594,330.13	571,086,121.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,417,164.00	5,318,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,417,164.00	5,318,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,409,164.00	5,318,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,409,164.00	5,318,600.00
120009	Бусад орлого	1,008,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521,177,166.13	565,767,521.07
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509,187,166.13	555,767,521.07
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	509,187,166.13	555,767,521.07
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,990,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,990,000.00	10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	526,554,330.13	570,379,721.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	526,554,330.13	570,379,721.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,906,730.13	569,959,721.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,668,786.73	413,559,585.66
210101	Үндсэн цалин	243,453,800.00	264,432,694.33
210102	Нэмэгдэл	142,995,300.00	125,520,802.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	972,000.00	11,380,085.87
210104	Урамшуулал	1,247,686.73	12,226,003.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,811,243.72	8,317,804.15
210201	Тэтгэврийн даатгал	-	120,450.43
210202	Тэтгэмжийн даатгал	-	14,170.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	11,336.51
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,834.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,811,243.72	8,169,012.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,873,053.97	50,426,439.14
210301	Гэрэл, цахилгаан	8,237,737.78	6,664,539.14
210302	Түлш, халаалт	39,665,696.19	39,501,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,969,620.00	4,260,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,131,890.77	17,865,477.12
210401	Бичиг хэрэг	1,887,810.00	2,416,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,894,540.00	11,228,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,542,695.77	2,825,067.12
210404	Ном, хэвлэл	2,450,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	132,700.00	108,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,224,145.00	1,287,710.00
2105	Нормативт зардал	24,720,710.20	32,034,628.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	669,690.00	918,348.00

210502	Хоол, хүнс	24,051,020.20	31,116,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,661,600.00	37,750,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,890,000.00	27,857,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	417,300.00	208,800.00
210604	Урсгал засвар	15,354,300.00	9,684,300.00
2107	Томилолт, зочны зардал	106,000.00	553,400.00
210702	Дотоод албан томилолт	106,000.00	553,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,048,678.74	8,577,187.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,401,778.74	7,519,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	599,400.00	379,487.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	938,500.00	554,500.00
210807	Газрын төлбөр	43,000.00	36,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,884,766.00	875,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,643,166.00	677,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	241,600.00	197,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,647,600.00	420,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	285,600.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	285,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,362,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,362,000.00	420,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	40,000.00	706,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	40,000.00	706,400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	40,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,000.00	746,400.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	138,665,624.90	326,341,020.47	194,478,368.32		659,485,013.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	138,665,624.90	326,341,020.47	194,478,368.32	0.00	659,485,013.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-17,868,222.19		-17,868,222.19
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	138,665,624.90	326,341,020.47	176,610,146.13	0.00	641,616,791.50
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	138,665,624.90	326,341,020.47	158,741,923.94	0.00	641,616,791.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	138,665,624.90	326,341,020.47	176,610,146.13	0.00	641,616,791.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			56,773,518.04		56,773,518.04
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	138,665,624.90	326,341,020.47	233,383,664.17	0.00	698,390,309.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	562,449,400.00	570,379,721.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,449,400.00	570,379,721.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	562,029,400.00	569,959,721.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	413,561,800.00	413,559,585.66
210101	Үндсэн цалин	263,608,800.00	264,432,694.33
210102	Нэмэгдэл	136,785,000.00	125,520,802.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,172,000.00	11,380,085.87
210104	Урамшуулал	1,996,000.00	12,226,003.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,998,800.00	8,317,804.15
210201	Тэтгэврийн даатгал	-	120,450.43
210202	Тэтгэмжийн даатгал	-	14,170.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	11,336.51
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,834.12
210205	Эрүүл мэндийн даатгал	11,998,800.00	8,169,012.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,735,600.00	50,426,439.14
210301	Гэрэл, цахилгаан	6,970,900.00	6,664,539.14
210302	Түлш, халаалт	39,501,000.00	39,501,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,263,700.00	4,260,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,867,300.00	17,865,477.12
210401	Бичиг хэрэг	2,416,200.00	2,416,200.00
210402	Тээвэр, шатахуун	11,228,000.00	11,228,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,826,700.00	2,825,067.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	108,500.00	108,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,287,900.00	1,287,710.00
2105	Нормативд зардал	32,037,100.00	32,034,628.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	920,800.00	918,348.00
210502	Хоол, хүнс	31,116,300.00	31,116,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,750,300.00	37,750,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,857,200.00	27,857,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	208,800.00	208,800.00
210604	Урсгал засвар	9,684,300.00	9,684,300.00
2107	Томилолт, зочны зардал	553,400.00	553,400.00
210702	Дотоод албан томилолт	553,400.00	553,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,650,000.00	8,577,187.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,591,900.00	7,519,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	379,500.00	379,487.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.00	554,500.00
210807	Газрын төлбөр	36,100.00	36,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	875,100.00	875,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	677,800.00	677,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	197,300.00	197,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,000.00	420,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	562,449,400.00	569,109,878.93
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	559,779,400.00	563,791,278.93
131001	Улсын төсвөөс санхүүжих	559,779,400.00	563,791,278.93
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,670,000.00	5,318,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,670,000.00	5,318,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		40,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		746,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Эрхэм зорилгоо “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тодруулбал Төрийн хэмнэлтийн хууль 2022 онд батлагдаж, мөрдөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57.4 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40.0	746.4	706.4
Авлага	0.0		
Бараа материал	39,638.3	43,883.3	4,245.0
Үндсэн хөрөнгө	601,978.5	654,507.0	52,528.5
Нийт хөрөнгө	641,656.8	699,136.7	57,479.9
Өр төлбөр	40.0	746.4	706.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	641,616.8	698,390.3	56,773.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	641,656.8	699,136.7	57,479.9

Дээрх хүснэгтэд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна. Үндсэн хөрөнгийн данс өмнөх оноос 52.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дээд шатны байгууллага болон бусад салбараас шилжүүлэн авсан, төсвийн хөрөнгөөр худалдан авсан, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж, дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 636.4 сая, үйл ажиллагааны орлогоос 2.6 сая, нийт зарлагыг 639.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 137.1 сая төгрөгөөр бууруулж, 501.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 60.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 559.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 2.6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 559.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 2.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 558.4 сая төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 4.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд АЗДТГ-аас сургалтын ухаалаг дэлгэц худалдан авах зардалд зориулж 10.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт орж, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал, албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулах, цахим дэлгүүрт байхгүй арван сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 588.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 3.5 сая төгрөгөөр, бараа, үйлчилгээний урсгал зардал 1.0 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал 7.0 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос буурсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

/мянган төгрөгөөр/

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.3 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрсэн бөгөөд уг алдааг дараагийн тайлант хугацаанд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 2 зөрчил² илэрсэн бөгөөд эдгээр зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй нь Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, сангийн сайдын 2022.12.23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 4.2 дахь "Алба ажлын автомашин нь Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын шаардлагыг хангасан байна." заалт, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын 8.4.3, 11.1 дэх заалттай нийцэхгүй байна. Албан ажлын автомашинуудад GPS суурилуулаагүй нь шатахууны зардалд хэмнэлт бий болохгүй байх сөрөг үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж:

Албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулж, жолоочийн тооцооны хуудаст автомашины явсан маршрутыг жолоочоор GPS-ийн мэдээлэлд үндэслэн дэлгэрэнгүй бичүүлж, хяналт тавьж, шатахууны зардалд хэмнэлт бий болгож ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Модем, мананцар үүсгэгч, дэлгэц, бойлер гэх мэт 0.5-1.2 сая төгрөгийн өртөгтэй, нийт 3.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бараа материалын дансанд бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС 12-Бараа материал, нь УСНББОУС 17-Үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

УСНББОУС болон “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т заасан “Үндсэн хөрөнгө”, “Бараа материал”-ын тодорхойлолтын дагуу үндсэн хөрөнгө, бараа материалыг ялгамжтай бүртгэх.

3. Цахим худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ." заасны дагуу хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээ цахим дэлгүүрт байхгүй тохиолдолд холбогдох бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 31 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн	1	3257.6	-	-	1	3257.6	-	-	1	3257.6	1	3257.6
Дүн	1	3257.6	-	-	1	3257.6	-	-	1	3257.6	1	3257.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан ажлын автомашинд GPS суурилуулаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
10 саяас дээш өртөг бүхий барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-